Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 (цаашид "Төсөл" гэх)-ын санхүүгийн тайлан нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс ("УСНББОУСЗ") гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартууд ("УСНББОУС"), Төслийн гэрээ, Төслийн удирдлагын гарын авлагад тусгагдсан санхүү нягтлан бодох бүртгэлийн холбогдох заалтууд, Азийн хөгжлийн банкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бэлтгэгдсэн болно. Тус Төслийн Удирдлага нь 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн хугацаан дахь Төслийн санхүүгийн байдлын тайлан, ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, тусгай дансны мөнгөн гүйлгээний тайлан, зарцуулалтын тайлан, нөхөн дүүргэлтийн тайланг уг өдрийн байдлаар үнэн зөв тусгасан эсэх баталгааг хариуцна.

Удирдлагын үүрэг нь төслийн санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлж чадах, зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтлөх бөгөөд санхүүгийн тайлангууд нь тодруулга 2-т дурдсан шаардлагуудад нийцсэн байхыг баталгаажуулах явдал болно.

Төслийн мөнгө, эд хөрөнгийг хадгалан хамгаалах, тэдгээрийг аливаа заль мэх, хэвийн бус үйлдлээс сэргийлэх, эдгээр үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь төслийн удирдлагын үүрэг юм.

Удирдлага нь 5-8 болон 12-25 дугаар хуудас дахь санхүүгийн тайлангуудыг үндэслэлтэй, зохистой дүн шинжилгээ болон тооцоогоор баримтжуулсан, тууштай мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг ашиглан бэлдсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж үзэж байна.

Төслийн удирдлагын шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:


Ц.Болормаа
Төслийн зохицуулагч


С.Оюунцэцэг
Төслийн санхүүгийн ажилтан

Улаанбаатар, Монгол Улс

Огноо:

2000000033



Эйч Эл Би Монголиа Аудит ХХК

Зөвлөх Үйлчилгээ ба Аудит, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Сүлжээ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын Гүйцэтгэх Удирдлагад

Дүгнэлт

Бид Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 ("Төсөл")-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, түсгай дансны мөнгөн гүйлгээний тайлан, зарцуулалтын тайлан, нөхөн дүүргэлтийн тайлан, болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг байдлын хувьд Төслийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, тухайн жилийн санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("УСНББОУСЗ")-өөс гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт ("УСНББОУС")-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Нягтлан бодогчдын олон улсын холбоо, Аудит ба Баталгаажуулалтын Стандартын Зөвлөл (АБОУСЗ)-өөс гаргасан Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НБЁЗОУСЗ")-ийн Мэргэжлийн Нягтлан бодогчдын Ёс Зүйн Дүрэм ("МНБЁЗД")-д дурдсан санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу төслөөс хараат бус байж дээрх шаардлагад тодорхойлсон ёс зүйн бусад шаардлагыг даган биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд тохиромжтой гэж итгэж байна.

Бусад асуудал

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 нь 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс үйл ажиллагаа нь эхэлсэн тул завсрын аудит хийгдээгүй.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Төслийн удирдлага нь Санхүүгийн тайлангуудыг УСНББОУС -ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас уусч болох материаллаг дүнг бүрүү илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.



Эйч Эл Би Монголиа Аудит ХХК

Зөвлөх Үйлчилгээ ба Аудит, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Сүлжээ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын Гүйцэтгэх Удирдлагад (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг хэмжээний алдаатайд тооцогдоно.

Нягтлан бодогчдын олон улсын холбооны вэб хуудсанд байршуулсан АОУС 700-ийн 38-аас 39-р зүйлийн (шинэчлэн найруулсан) дагуу хийх аудитын ажлын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан.

ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК



Чүлтэмдоржийн Энхтуяа, Партнер

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Чингисийн өргөн чөлөө 8-1,
Гүрван Гал оффис төв, 607 тоот

Огноо: 2022 оны 05 дугаар сарын 12

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тод	2021.12.31 ам.доллар	2021.06.07 ам.доллар
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3	443,956.73	-
Дансны авлага	4	19.66	-
Бараа материал	5	231.52	-
Нийт эргэлтийн хөрөнгийн дүн		444,207.91	-
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө		-	-
Биет бус хөрөнгө		-	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө		-	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		444,207.91	-
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Өглөг	6	19.66	-
Нийт богино хугацаат өр төлбөр		19.66	-
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	7	42,225,870.23	-
Нийт урт хугацаат өр төлбөр		42,225,870.23	-
Нийт өр төлбөр		42,225,889.89	-
ЭЗДИЙН ӨМЧ			
Өмнөх оны үр дүн		-	-
Тайлант оны үр дүн		(41,781,681.98)	-
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		(41,781,681.98)	-
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		444,207.91	-

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТЛАГДСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

	Тод	2021.12.31 ам.доллар	2021.06.07 ам.доллар
ОРЛОГО			
АХБ-ны санхүүжилтийн орлого		-	-
Монгол улсын Засгийн газрын эх үүсвэр		-	-
Хүү амлалтын шимтгэл		-	-
Банкны хүүний орлого		-	-
Бусад орлого		-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний ашиг		-	-
ОРЛОГЫН ДҮН		-	-
ЗАРДАЛ			
Хөрөнгө оруулалтын зардал			
Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж	8	41,743,390.23	-
Төслийн удирдлага	9	32,126.22	-
Урсгал зардал	10	2,660.53	-
Санхүүгийн зардал	11	3,480.00	-
Банкны шимтгэл	12	25.00	-
ЗАРДЛЫН ДҮН		41,781,681.98	-
Тайлант үеийн ашиг		(41,781,681.98)	-

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Тод	Засгийн газрын хувь оролцоо ам.доллар	Бусад ам.доллар	Тайлант үеийн үр дүн ам.доллар	Хувьцаагаарх мөнгө ам.доллар	Нийт цэвэр хөрөнгө/өмч ам.доллар
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулга	-	-	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	-	-	-	-	-
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулга	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(41,781,681.98)	-	(41,781,681.98)
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	-	-	(41,781,681.98)	-	(41,781,681.98)

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Тод	2021.12.31 ам.доллар	2021.06.07 ам.доллар
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлого			
АХБ-ны санхүүжилт		-	-
Хүлээн авсан хүү		-	-
Бусад мөнгөн орлого		-	-
Нийт мөнгөн орлогын дүн		-	-
Мөнгөн зарлага			
Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж		41,743,390.23	-
Ажилчдын зардал		32,126.22	-
Урсгал зардал		2,892.05	-
Банкны шимтгэл		-	-
Нийт мөнгөн зарлагын дүн		41,778,408.50	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(41,778,408.50)	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн төлбөр		-	-
Биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн төлбөр		-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Хүлээн авсан зээл		42,222,365.23	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		42,222,365.23	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/(алдагдал)		-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		443,956.73	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		443,956.73	-

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТЛАГДСАН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН**

	31/12/2021-ний өдрөөрх хуримтлагдсан дүн ам.доллар	Тайлант он ам.доллар	07/06/2021-ны өдрөөрх хуримтлагдсан дүн ам.доллар
Санхүүжилтийн эх үүсвэр			
АХБ-ний санхүүжилт-L4051	22,129,408.87	22,129,408.87	-
АХБ-ний санхүүжилт-L4052	20,096,461.36	20,096,461.36	-
Монгол Улсын засгийн газрын оролцоо	212,021,203.35	212,021,203.35	-
Банкны хүүний орлого	-	-	-
Бусад орлого- Тендерийн орлого	-	-	-
Нийт санхүүжилтийн эх үүсвэр	254,247,073.58	254,247,073.58	-
Зээлийн зарцуулалт			
ХМХ-ийн мөнгөн тэтгэмж-L4051	22,129,408.87	22,129,408.87	-
ХМХ-ийн мөнгөн тэтгэмж-L4052	19,613,981.36	19,613,981.36	-
ХМХ-ийн мөнгөн тэтгэмж-МУЗГ	212,021,203.35	212,021,203.35	-
Бараа, үйлчилгээ	-	-	-
Зөвлөх үйлчилгээ	-	-	-
Төслийн удирдлага	35,018.27	35,018.27	-
Хүү амлалтын төлбөр-L4052	3,480.00	3,480.00	-
Банкны шимтгэл	25.00	25.00	-
Гадаад валютын ханшийн бууралт	-	-	-
Нийт зарцуулалтын дүн	253,803,116.85	253,803,116.85	-
Цэвэр санхүүжилт	443,956.73	443,956.73	-

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТЛАГДСАН ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эх үүсвэр ба зардлын төрөл	Нийт санхүүжилтийн хуваарилагдсан дүн ам.доллар	Санхүүжилтийн зарцуулалтын гүйцэтгэл			Санхүүжилтийн зарцуулалтын гүйцэтгэл %		
		2021/06/07-ноорх хуримтлагдсан дүн ам.доллар	Тайлант жил ам.доллар	2021/12/31-нээрх хуримтлагдсан дүн ам.доллар	2021.06.07	2021.12.31	Нийт
L4051							
A. Хөрөнгө оруулалтын зардал							
ХМХ-ийн мөнгөн тэтгэмж	26,360,000.00	-	22,129,408.87	22,129,408.87	-	84.0%	84.0%
Хүүгийн төлбөр	240,000.00	-	-	-	-	-	-
L4052							
A. Хөрөнгө оруулалтын зардал							
ХМХ-ийн мөнгөн тэтгэмж	41,770,000.00	-	19,613,981.36	19,613,981.36	-	47.0%	47.0%
Бараа, үйлчилгээ	3,160,000.00	-	-	-	-	-	-
Зөвлөх үйлчилгээ	420,000.00	-	-	-	-	-	-
Төслийн удирдлага	240,000.00	-	-	-	-	-	-
B. Магадлашгүй зардал	300,000.00	-	-	-	-	-	-
C. Хэрэгжүүлэх явцын санхүүгийн төлбөр	510,000.00	-	3,480.00	3,480.00	-	0.7%	0.7%
Монгол Улсын Засгийн Газрын санхүүжилт							
A. Хөрөнгө оруулалтын зардал							
ХМХ-ийн мөнгөн тэтгэмж	186,320,178.00	-	212,503,683.35	212,503,683.35	-	114.1%	114.1%
Бараа, үйлчилгээ	319,822.00	-	-	-	-	-	-
Нийт дүн	259,640,000.00	-	254,250,553.58	254,250,553.58	-	97.9%	97.9%

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТЛАГДСАН ТУСГАЙ ДАНСНЫ ТАЙЛАН**

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Хэсэг А- Дансны хөдөлгөөн		
Эхний үлдэгдэл	-	-
Нэмэх нь:		
Тайлант жилд хүлээн авсан мөнгө	-	-
АХБ-наас авсан урьдчилгаа	479,000.00	-
Дэд данснаас орж ирсэн мөнгө	-	-
Хүүний орлого	-	-
Хасах нь:		
Төгрөгийн дэд дансруу шилжүүлсэн	-	-
Ам долларын дэд дансанд шилжүүлсэн	37,216.49	-
Бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн төлбөр	-	-
Төслийн удирдлагын зардал	25.00	-
Эцсийн үлдэгдэл	441,758.51	-
Хэсэг Б- Банкны тохируулга		
АХБ-ны урьдчилгааны дүн	479,000.00	-
Тусгай дансны тайлант жилийн үлдэгдэл	441,758.51	-
Нэмэх:		
Зарцуулсан боловч нэхэмжлээгүй дүн	35,018.27	-
Нэхэмжилсэн боловч санхүүжүүлээгүй дүн	-	-
Төрийн сангийн дансны үлдэгдэл	2,198.22	-
Тендертэй холбоотой зардал	-	-
Банкны шимтгэл	25.00	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
Хасах:		
Хүүний орлого	-	-
Тендерийн бичиг баримтын орлого	-	-
Тусгай дансны нийт урьдчилгааны дүн	479,000.00	-

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
 АУДИТЛАГДСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

Зардлын төрөл/Нөхөн дүүргэлт	ХМХ-ийн мөнгөн тэтгэмж ам.доллар	Бараа, үйлчилгээ ам.доллар	Зөвлөх үйлчилгээ ам.доллар	Төслийн удирдлага ам.доллар	Нийт ам.доллар
L4051					
WA#51001	5,321,643.17	-	-	-	5,321,643.17
WA#51002	16,807,765.70	-	-	-	16,807,765.70
L4052					
WA#52001	9,282,866.29	-	-	-	9,282,866.29
WA#52002	10,331,115.07	-	-	-	10,331,115.07
Нийт	41,743,390.23	-	-	-	41,743,390.23
Зарцуулалт	41,743,390.23	-	-	-	41,743,390.23
Зөрүү	-	-	-	-	-

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН
АУДИТЛАГДСАН ТУСГАЙ ДАНСНЫ НӨХӨН ДҮҮРГЭЛТИЙН ТАЙЛАН

Санхүүжилтийн хүсэлтийн дугаар	Санхүүжилтийн төрөл	Нэхэмжилсэн дүн ам.доллар	Санхүүжигдсэн дүн ам.доллар	Зөрүү ам.доллар
WA#51001	Шууд төлбөр	5,321,643.17	5,321,643.17	0.00
WA#52001	Шууд төлбөр	9,282,866.29	9,282,866.29	0.00
WA#51002	Шууд төлбөр	16,807,765.70	16,807,765.70	0.00
WA#52002	Шууд төлбөр	10,331,115.07	10,331,115.07	0.00
WA#52003	Урьдчилгаа төлбөр	479,000.00	479,000.00	0.00
Нийт		42,222,390.23	42,222,390.23	0.00

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1. Төслийн танилцуулга

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Засгийн Газар (ЗГ), Азийн Хөгжлийн Банк (АХБ) хооронд 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ийг хэрэгжүүлэхэд АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэр (ЕХЭҮ)-ээс санхүүжигдэх 46,400,000.00 ам.долларын ердийн зээл 4052-МОН, 26,600,000.00 ам.долларын хөнгөлөлттэй зээл 4051-МОН дугаартай зээлүүдийг олгохоор болсон. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 5-р сарын 10-ны өдөр тус зээлийг соёрхон баталсан. Төсөл хэрэгжиж дуусах хугацаа 2023 оны 12 дугаар сарын 31 байна.

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын зорилго:

Төслийн гол зорилго нь цар тахлын үед зорилтот, эмзэг бүлгийн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд нийгмийн халамжийн дэмжлэгийг сайжруулна.

1.2 Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын бүрэлдэхүүн хэсэг

Уг төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- 2021 оны 01 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл 6 сарын хугацаанд цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд нэмэлтээр сар бүр олгох хүүхдийн тэтгэмжийн нэмэлт хувийг санхүүжүүлэх;
- Ирээдүйд гарах хямралд өрхийн даван туулах чадвар болон засгийн газрын хариу арга хэмжээг сайжруулахын тулд дараах гурван чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх юм.
 - Орлого орлуулан тооцох аргачлалаар хийх дараагийн судалгааг шинэ аргачлалаар явуулахад дэмжлэг үзүүлэх замаар бодит хэрэгцээтэй иргэдэд хүрч үйлчлэх үүднээс зорилтот бүлгийг тогтоох систем болон өрхийн мэдээллийн нэгдсэн санг илүү нарийвчилсан өгөгдлөөр шинэчлэх
 - Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг “ehalamj” системд холбож, тэтгэмж, үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай болгох
 - Төгсөлтийн аргачлалын амьжиргааг сайжруулж, чадваржуулахад чиглэсэн цогц арга хэмжээ бүхий бэлэн мөнгөн тэтгэмж дээр суурилсан нийгмийн хамгааллын шинэлэг хөтөлбөр болгон туршиж үнэлгээ хийх

Төслийн нийт санхүүжилтийн төлөвлөгөө дараах байдалтай байна.

(сая ам.доллар)

Зориулалт	АХБ	Засгийн Газар	Нийт
А. Хөрөнгө оруулалтын зардал			
1.Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж	68.13	186.32	254.45
2.Бараа, үйлчилгээ	3.16	0.32	3.48
3.Зөвлөх үйлчилгээ	0.42	0.00	0.42
4.Төслийн удирдлага	0.24	0.00	0.24
Дэд нийлбэр (А)	71.95	186.64	258.59
В. Магадалшгүй			
1.Биет	0.15	0.00	0.15
2.Үнийн	0.15	0.00	0.15
Дэд нийлбэр (В)	0.30	0.00	0.30
С. Хэрэгжүүлэх явцын санхүүгийн төлбөр	0.75	0.00	0.75
Төслийн нийт зардал (А + В + С)	73.00	186.64	259.64

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1. Төслийн танилцуулга (Үргэлжлэл)

1.3 Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 нь тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:

Төслийн үр дүн, үр дүнд хүрэх явц:

(i) Үр дүн 1: Зорилтот бүлгийн хүүхдүүдийн тэтгэмжийн нэмэгдлийг хүргэсэн

Энэхүү төсөл нь Ковид-19 цар тахлын үед зорилтот бүлгийн иргэд, тэр дундаа эмзэг бүлгийн эмэгтэйчүүд, хүүхдүүдийн амьжиргааг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлж ирсэн. УИХ-ын 6 дугаар сарын 29-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу 6 дугаар сард дуусгавар болох байсан Хүүхдийн мөнгийг нөхөн олгох ажил 2021 оны 12-р сарыг хүртэл үргэлжилж байна. 2021 оны 3-р улирлын мэдээгээр хүүхдийн мөн хөтөлбөрт бүртгүүлсэн нийт хүүхдийн тоо 2021 оны 1-р сард 1.19 сая орчим байсан бол 2021 оны 6-р сард 1.21 сая болж, сар бүр нэмэгдэж байна. Хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдаж буй нийт хүүхдийн 48.8 гаруй хувийг охид эзэлж байна.

(ii) Үр дүн 2. Нийгмийн халамжийн хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлсэн.

Үр дүн 2-т (i) Зорилтот бүлгийг шинэчлэн тогтоох, (ii) нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг цахимжуулах, (iii) эдийн засгийн оролцоог хангах хөтөлбөрийг түрших (Төгсөлтийн арга) зэрэг гурван үндсэн үйл ажиллагааг багтаасан болно.

(i) зорилтот бүлгийг шинэчлэн тогтоох. Энэ үйл ажиллагаанд гадаадын 1, дотоодын 1, нийт 2 зөвлөхийг оролцуулах бөгөөд зорилтот бүлгийг шинэчлэхэд чиглэсэн шинэ шатны судалгаанд дэмжлэг болох үйлчилгээ болон хангамжийг худалдан авах юм. Энэ нь ХНХЯ болон ТББ-ын зүгээс орлого орлуулан тооцох (ООТ) аргачлалыг 2022 оны эхний улиралд шинэчлэх хүртэл хойшлогдсон байна.

(ii) нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг цахимжуулах үйл ажиллагаа. Энэ үйл ажиллагаанд мэдээллийн технологи (МТ)-ын тоног төхөөрөмж, програм хангамжийг худалдан авах ба бие даасан 6 МТ-ын зөвлөхийг хамруулна.

(i) ба (ii) үйл ажиллагааны хувьд ХНХЯ болон ХХҮЕГ нь Төслийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд хэд хэдэн зохицуулалтыг санал болгосон. Зохицуулалтад нэмэлт 3 бие даасан зөвлөх, хүн-сарын тоонд өөрчлөлт оруулах, худалдан авах арга болон худалдан авах бүтээгдэхүүний багцын нэрд өөрчлөлт оруулахыг тусгасан. Гааль, Татвар, Санхүүгийн Мэдээллийн Технологийн Төв нь “ehalamj” системийг хөгжүүлж байсан бөгөөд 2021 оны 12 сард хэд хэдэн модулийг хөгжүүлэлгүйгээр системийг ХХҮЕГ-ын МТ-ын Төвд хүлээлгэн өгөхийг зорьж байсан. ООТ аргачлалын системийг шинэчлэх тухайн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэг зөвлөх тусгасан байсан хэдий ч, системийг урьд нь 3 МТ-ын зөвлөхтэй багаар хөгжүүлж байсан ба ХХҮЕГ нь нэг зөвлөх энэ ажилд хангалтгүй гэж үзэн нэмэлтээр 2 зөвлөх авах санал гаргасан. Үүний тулд, ХХҮЕГ-ын МТ-ын Төвд ООТ аргачлалыг шинэчлэх болон “ehalamj” системийг хөгжүүлэхэд нэмэлт техникийн нөөц шаардлагатай болно. Нэмэлт зөвлөхүүд авах хэдий ч, хэд хэдэн зөвлөхийн хүн-сарын тоо цөөрсөн тул нэмэлт зөвлөхүүдийг хүн-сар буурсан зөвлөхүүдээс хэмнэсэн мөнгөөр цалинжуулах тул бүх зөвлөхөд зарцуулах нийт зардал нэмэгдэхгүй.

G001 багцад шууд гэрээний аргын дагуу жил бүр техникийн дэмжлэг үзүүлдэг Oracle Exadata машин багтсан болно. ХХҮЕГ нь өөр өөр компаниудын бүтээсэн бүтээгдэхүүнүүдийг худалдан авахыг зорьж байсан тул шууд гэрээний арга нь нэг компанийн бүтээсэн бүтээгдэхүүнүүдэд илүү тохиромжтой гэж үзэн багцын нэр болон худалдан авах аргыг өөрчлөхийг санал болгосон.

Нэмж дурдахад, ХНХЯ нь АХБ-аас 12-р сард ООТ аргачлалыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, бараа агуулсан G003 болон G004 багцуудыг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс хасч, харин зардлыг бараа/үйлчилгээний ангилалд байлгахыг хүссэн. Учир нь багцын хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа нь худалдан авах ажиллагааны журам шаардлагагүй бөгөөд харин төслөөс санхүүждэг төв, орон нутгийн нийгмийн халамжийн ажилтнуудаар явуулах юм.

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1. Төслийн танилцуулга (Үргэлжлэл)

1.3 Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 нь тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн (Үргэлжлэл)

Үр дүн 2. Нийгмийн халамжийн хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлсэн (Үргэлжлэл).

ХХҮЕГ-ын Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг өөрчлөх саналыг зөвлөхүүдийн ажлын даалгаврын хамт 2021 оны 12-р сард хянаж, батлуулахаар АХБ руу хүргүүлсэн.

(iii) Эдийн засгийн оролцоог хангах хөтөлбөрийг түрших (Төгсөлтийн арга) үйл ажиллагаа. Төгсөлтийн туршилтын хөтөлбөрт Хэрэгжүүлэх түнш ТББ, Зах зээлийн үнэлгээний компани болон Хэвлэл мэдээлэл, харилцааны компанийг оролцуулна. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш ХНХЯ-аас хөтөлбөрийг нийгмийн халамжийн хууль тогтоомжийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн хэрэгжүүлэх зорилгоор төрийн бүс байгууллагад зохицуулалт хийх хүсэлт тавьсан. Үүний үр дүнд төгсөлтийн туршилтын хөтөлбөр болон зөвлөхийн ажлын даалгаварт хэд хэдэн өөрчлөлт орсон.

Үүний дагуу 9 дүгээр сарын 29-ний өдөр Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг (Хувилбар 1) шинэчилсэн бөгөөд үүнд Ашиг хүртэгчдийн амьжиргааг дэмжих хөрөнгө болон G002, Нөлөөллийн үнэлгээний компани C009 багцуудыг нэгтгэсний үр дүнд Хэрэгжүүлэх түнш ТББ-ын C010 багц багтсан болно. Энэ багцыг Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулах (ДӨТШ) аргаар худалдан авах ба урьдчилан тодорхойлсон 5 ТББ-аас чанарт суурилсан сонгон шалгаруулах (ЧСС) аргад үндэслэн шаардлагад нийцсэнийг нь сонгон шалгаруулах болно.

2021 оны 11 дүгээр сард ХНХЯ нь илүү олон байгууллага тендерт оролцох боломжийг олгох үүднээс C010 багцын худалдан авах аргыг ДӨТШ-аас нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (НӨТШ) болгон өөрчлөхийг АХБ-наас хүссэн. Гэсэн хэдий ч зөвхөн ТББ-уудад зориулсан НӨТШ-ын журам байдаггүй тул компаниуд оролцох боломжтой болох бөгөөд энэ нь ТББ болон бизнесийн компаниудын хооронд шударга бүс өрсөлдөөн үүсэж болзошгүй гэж үзсэн юм.

2021 оны 12 дугаар сарын 17 гэхэд, ХНХЯ нь C010 багцын ажлын удирдамжийг өөрчилсөн ба Дэлхийн банкны Нийгмийн Хамгааллын Системийг Бэхжүүлэх Төсөлд багтсан ЭА-ын сонгон авсан зөвлөхийн гаргасан Монгол улс дахь төгсөлтийн туршилтын туршлага, сургамжиний үнэлгэнд тусгагдсан жагсаалт дээр тулгуурлан 12 төрийн бүс байгууллагыг урьдчилан тодорхойлсон 5 ТББ дээр нэмж, оролцох ТББ-уудын тоог нэмэгдүүлсэн юм. ХНХЯ ажлын удирдамжид өөрчлөлтүүд оруулсны дотор хугацааг 24 сар байсныг 22 сар болгон богиносгосон байна. Зөвлөх Сонгон Шалгаруулах Хороо 12 дугаар сард хурлаа хийсэн ба 2022 оны 1 дүгээр сарын 5-нд эхний материалаа хүлээн авсан юм.

(iii) Төслийн бусад хөгжүүлэлт. Төсөл нь жендэрийн хандлагад үр нөлөөтэй байхаар ангилагдсан, ба хүүхдийн мөнгөний нэмэлт санхүүжилт болон нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг олгох замаар эмэгтэйчүүд, хүүхдүүдэд тус дэм үзүүлэх зорилготой юм. Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ЖҮАТ)-нд тодорхой 3 үйл ажиллагаа, 5 зорилт/үзүүлэлт багтсан Зураг төсөл боловсруулах, дизайн хяналт-шинжилгээний хүрээ нь жендэрийн гол үзүүлэлтүүдийг багтаасан.

Төслийн Удирдлагын Гарын Авлагын дагуу C010 багцын Зөвлөхийг НӨАТ-аас чөлөөлөхийн тулд ТХН-ээс шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн.

(iv) Төслийн хэрэгжилтийн явц. 2022 оны 1 дүгээр сарын байдлаар Төслийн хэрэгжилтийн явц 23.5%, Үр дүн 1-ийн бодит явц 82.7%, үр дүн 2-ын бодит явц 8.8% байна.

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1. Төслийн танилцуулга (Үргэлжлэл)

1.4 Төслийн удирдах хороо /Төсөл удирдах нэгж/

Төслийн Удирдах Хороог ХНХ-ын Сайдын 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн А/129 дугаар тушаалаар байгуулсан. Тайлант хугацаанд уг Хорооны 2 удаагийн хурлыг зохион байгуулав. Анхны хурлыг 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, нийт төслийн хүрээний үйл ажиллагаа болон төслийн хүрээнд Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөрийн төлөвлөлт, хуваарийг танилцуулсан. Түүнчлэн, төслийн 2021 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулахад чиглэж ажиллав. 2 дахь хурлыг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан бөгөөд төслийн хэрэгжилтийн явц болон ТХН-ийн ажилтнуудын Хөлсөөр ажиллах гэрээний биелэлтийн үнэлгээг танилцуулж, зөвлөмж гаргасан.

Төслийн Удирдах Хороо дараах бүрэлдэхүүнтэй байна.

№	Бүрэлдэхүүн	Албан тушаал
1	Төслийн удирдах хорооны дарга	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга
2	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
3	Төслийн удирдах хорооны гишүүн	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга
4	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
5	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
6	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга
7	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэдээлэл технологи, статистикийн хэлтсийн дарга
8	Төслийн удирдах хорооны гишүүн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
9	Төслийн удирдах хорооны гишүүн	Азийн хөгжлийн банкны Монгол улс дахь Суурин төлөөлөгчийн газрын ахлах мэргэжилтэн
10	Төслийн удирдах хорооны нарийн бичгийн дарга	ТХН Төслийн Зохицуулагч

1.5 Төсөл хэрэгжүүлэх нэгж

АХБ, Монгол Улсын Засгийн газрын хооронд зээлийн гэрээ байгуулж, 2021 оны 6 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсноор Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоо, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 106 дугаар тушаалаар батлуулсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан түс бүр Хөлсөөр ажиллах 2021 оны гэрээг ХНХЯ, СЯ-тай зохих журмын дагуу байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төслийн 194.3 тэрбум төгрөгийн төсвийн төсөөллийг хүргэж зохих журмын дагуу батлуулсан. 2021 оны 12 дугаар сарын байдлаар гүйцэтгэл 119.0 тэрбум төгрөг байна. Үүнд, Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн тусламжид буюу төслийн 1 дүгээр Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд АХБны журам, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зардлын тайланг ХНХЯ, СЯ-аар хянуулан баталгаажуулж АХБ-наас 4 удаагийн санхүүжилтээр нийт 118.9 тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгө хөтөлбөрт төсвийн дэмжлэг болгон татан төвлөрүүлсэн.

АХБ-наас зохих хууль, дүрэм, журмын дагуу төслийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мөнгөн хөрөнгөнд 479.0 мянган ам. долларыг төслийн тусгай дансанд татан төвлөрүүлсэн. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлын дэд данснаас хийгдэх санхүүжилтийн төсвийг улирал бүр бэлтгэн ХНХЯ болон СЯ-аар хянуулан батлуулж, батлагдсан төсөвт багтаан зарцуулалтыг хийж байна.

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

I. **Тайлангийн бүрэлдэхүүн**

Төслийн санхүүгийн тайлан нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

1. Санхүүгийн байдлын тайлан
2. Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан
3. Өмчийн өөрчлөлтийн тайлан
4. Тусгай дансны мөнгөн гүйлгээний тайлан
5. Тусгай дансны нөхөн дүүргэлтийн тайлан
6. Зарцуулалтын тайлан

II. **Тайлан бэлтгэсэн үндэслэл**

Төслийн санхүүгийн тайланг УСНББОУС-ын стандартад нийцүүлэн Азийн хөгжлийн банкны Төслийн удирдлагын гарын авлага, Зээлийн гэрээний санхүү нягтлан бодох бүртгэлийн заалтуудыг мөрдөж гаргана.

III. **Тайлангийн хэмжилт**

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт зээлийн гэрээнд заасан валют болох ам.доллараар тайлагнасан. Ам.доллараас бусад валютаар илэрхийлсэн мөнгөн зүйлсийн үлдэгдлийг ам.доллараар илэрхийлэхдээ тайлангийн тасалбар болгосон өдрийн Монгол банкны албан ханшийг, мөнгөн бус зүйлсийн хувьд түүхэн ханш ашигласан. Төгрөгөөр хийгдсэн гүйлгээг ам долларт шилжүүлэхдээ үйл ажиллагааны дансанд зузаатгалын зорилгоор арилжаа хийгдсэн ханшаар тухайн зузаатгал дуусах хүртэл шилжүүлэн тооцож бүртгэнэ. Ханшийн зөрүүнээс үүссэн ашиг алдагдлыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгана.

IV. **Тайлангийн толилуулга**

Төслийн санхүүгийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн үлдэгдлийг эхний үлдэгдэл болгон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон дансдын үлдэгдлийг өссөн дүнгээр илэрхийлнэ.

V. **Тайланг хянах байгууллага**

Азийн хөгжлийн банк, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний Аудитын газар

VI. **Бүртгэл мэдээллийн систем**

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Acolous программ хангамж ашигладаг.

VII. **Орлого**

Азийн хөгжлийн банкны санхүүжилт болон Засгийн газрын татварын чөлөөлөлтийг аккурэл сууриар бүртгэнэ. Мөн дансны хүүний орлого, тендерийн орлогыг бүртгэнэ.

VIII. **Зардал**

Зарцуулалтыг зориулалтын дагуу аккурэл сууриар бүртгэнэ.

IX. **Тусгай данс**

Зээлийн тусгай дансыг Азийн хөгжлийн банкны зөвшөөрлөөр Төрийн сан банкинд байршдаг.

X. **Бараа болон зөвлөх бус үйлчилгээний худалдан авалт**

ТХН нь хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагуудын нэрийн өмнөөс төслийн хүрээнд худалдан авах ажиллагааг хариуцах болно. Худалдан авалт нь АХБ-ны Худалдан авах ажиллагааны бодлого (2017 онд батлагдсан, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт), АХБ-ны зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журам (2017 онд батлагдсан, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт)-ын дагуу явагдана.

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)

Х. Бараа болон зөвлөх бус үйлчилгээний худалдан авалт (Үргэлжлэл)

АХБ-наас өөрөөр тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд бараа, зөвлөх бус үйлчилгээний худалдан авахад доорх аргуудыг хэрэглэнэ.

Арга	Тайлбар
Бараанд шууд гэрээлэх	Мэдээллийн сангийн програм хангамж худалдан авах; урьдчилсан хяналт
Бараанд нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт	Дотоодын зар; урьдчилсан хяналт
Барааны үнийн санал авах хүсэлт	Дараа хяналт
Зөвлөхийн бус үйлчилгээнд үнийн санал авах хүсэлт	Анхны гэрээнд урьдчилсан хяналт тавина; дараагийн гэрээнүүдэд дараа хяналт тавина

Шүүд гэрээ байгуулах, дотоодод зарлах нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (НӨТШ), үнийн санал авах хүсэлт (ҮСХ)-ийн журмыг бараа, зөвлөхгүй үйлчилгээ худалдан авахад ашиглана. Нийгмийн халамжийн хөтөлбөрийг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх мэдээллийн сангийн програм хангамж, техник хангамжийг худалдан авахад шууд гэрээ байгуулна. Засгийн газрын Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн хүлээсэн чиг үүргийн дагуу бусад яамдад ашигладаг Oracle мэдээллийн сангийн системтэй нийцтэй байдлыг хангах үүднээс мэдээллийн сангийн системийг АНУ-ын Oracle корпорациас шууд худалдан авах болно. Дотоодод зарлах НӨТШ-ийг төгсөлтийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн иргэдэд амьжиргаагаа сайжруулах жижиг тоног төхөөрөмж худалдан авахад ашиглах болно. ҮСХ журмыг төгсөлтийн туршилтын хөтөлбөрт зориулан (i) зах зээлийн судалгааны үйлчилгээ, мөн (ii) хэвлэл мэдээллийн үйлчилгээг худалдан авахад ашиглах болно.

XI. Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт

Худалдан авалт нь АХБ-ны Худалдан авах ажиллагааны бодлого (2017 онд батлагдсан, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт), АХБ-ны зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журам (2017 онд батлагдсан, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт)-ын дагуу явагдана. АХБ-наас өөрөөр тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвлөх үйлчилгээний худалдан авахад доорх аргуудыг хэрэглэнэ.

Арга	Тайлбар
Чанарт суурилсан сонгон шалгаруулалт	Хялбарчилсан техникийн санал; урьдчилсан хяналт
Зөвлөхийн мэргэжлийн чадварт суурилсан сонгон шалгаруулалт	Биодата техникийн санал; урьдчилсан хяналт
Хувь зөвлөх сонгон шалгаруулалт	Урьдчилсан хяналт

Төслийн хүрээнд олон улсын 1 зөвлөх (8 хүн-сар), 7 үндэсний зөвлөх (80 хүн-сар)-өөс үйлчилгээ авах шаардлагатай. Зөвлөхүүдийг зөвлөх хувь хүн сонгон шалгаруулах аргыг ашиглан авч ажиллуулна. Ядуурлын зорилтот бүлэгт чиглүүлэх аргачлал (орлого орлуулан тооцох аргачлалын туршилтын судалгаа, өрхийн мэдээллийн нэгдсэн сан) дээр ажиллах олон улсын зөвлөх, үндэсний 2 зөвлөхийг ХНХЯ-нд ажиллуулна. Нийгмийн хамгааллын хөтөлбөрийг “e-halamj” системд холбон цахимжуулах ажил дээр үндэсний таван зөвлөх ажиллахаас 3 нь Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн төвд, 2 нь ХНХЯ-нд тус тус ажиллана. Зөвлөхүүдийн мэргэжлийн чадварт суурилсан сонгон шалгаруулах аргачлалын дагуу төгсөлтийн туршилтын судалгаа, нөлөөллийн үнэлгээ хийх үндэсний зөвлөх компанийг сонгон шалгаруулж авна.

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2-ЫН ДАГАЛДАХ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД:**

3. Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Дамжуулах данс	-	-
Урьдчилгаа данс	441,758.51	-
Дэд данс	2,198.22	-
	443,956.73	-

Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө дансанд дамжуулах данс, урьдчилгаа данс болон ТХН-ийн үйл ажиллагааны дэд дансны гүйлгээ хамаарна. Урьдчилгаа дансанд АХБ-ны санхүүжилтийг татан авч төлөвлөрүүлэн дэд дансруу шилжүүлж үйл ажиллагааны зардал болон бусад холбогдох зардлыг төлдөг.

4. Дансны авлага

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Дансны авлага	-	-
Ажилчдаас авах авлага	19.66	-
	19.66	-

5. Бараа материал

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Бичиг хэргийн материал	-	-
Түлш, шатах тослох материал	-	-
Хангамжийн материал	231.52	-
	231.52	-

6. Өглөг

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Цалингийн өглөг	8.42	-
ХХОАТ-ын өглөг	11.24	-
	19.66	-

7. Урт хугацаат өр төлбөр

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Урт хугацаат зээл	42,225,870.23	-
	42,225,870.23	-

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

8. Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
ХМХ-ийн мөнгөн тэтгэмж	41,743,390.23	-
	41,743,390.23	-

9. Төслийн удирдлага

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
ТХН-ийн ажилчдын цалин	28,556.01	-
НДШ-ын зардал	3,570.21	-
	32,126.22	-

10. Урсгал зардал

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Бичиг хэргийн зардал	529.09	-
Шатахуун, сэлбэг хэрэгсэл	351.06	-
Шуудан холбооны зардал	441.85	-
Зар сурталчилгааны зардал	449.26	-
Засварын зардал	63.19	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	737.25	-
Бусад зардал	88.83	-
	2,660.53	-

11. Санхүүгийн зардал

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Хүү амлалтын шимтгэл	3,480.00	-
	3,480.00	-

12. Банкны шимтгэл

	2021.12.31	2021.06.07
	ам.доллар	ам.доллар
Дамжуулагч банкны шимтгэл	25.00	-
Банкны шимтгэл	-	-
	25.00	-

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

13. Тайлангийн дараах үйл явдал

2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 48 тоот “Жагсаалт батлах тухай” Сангийн сайдын тушаалын хавсралтаар Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын дотоодын зах зээлээс худалдан авах бараа, үйлчилгээг НӨАТ-с чөлөөлсөн байна.

Тайлангийн хугацаанаас хойшхи энэ үйл явдал нь УСНББОУС 14-т заасны дагуу төслийн нэгж нь үл залруулагдах тайлангийн дараах үеийн үйл явдал гэж тогтоожээ. Иймд, 2021 оны 12-р сарын 31-ний өдөр болон тухайн жилийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг тэдгээрийн нөлөөллийг тусгахаар тохируулаагүй болно.

14. Монгол хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.